



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан Өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн зориулалттай хавсралтад заасан нийт 1,749,312,472.82 (нэг тэрбум долоон дөчин есөн сая гурван зуун арван хоёр мянга дөрвөн зуун далан хоёр төгрөг наян хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн өмчид, 33,992,700.00 (гучин гурван сая есөн зуун ерэн хоёр мянга долоон зуун) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид тус тус бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Жамбалцэрэн, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга Ш.Үнэнбат, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



300470

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны дугаар сарын 17-ны өдрийн
14 дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК БОЛОН НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

3	Хөрөнгийн нэр	Хүчин чадал	Хүчин чадал		Нэгжийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/	Бүртгэх хуулийн этгээд
			хэмжих нэгж	биет хэмжээ			
1	ӨХЭДТөвийн барилга	Тэнхэлгээрээ 12*18 зоорьтой 3 давхар төмөр бетон краказтай	м.кв	864	1,900,505.15	1,642,036,449.60	
2	Бохир усны цооног	Төмөр бетон цутгамал 10 м3	м.куб	10	3,480,802.80	34,808,028.00	
2	Камер	Дотор камер ip	ш	5	226,000.00	1,130,000.00	
3	Дэлгэц	19 inch LED DELL	ш	1	280,000.00	280,000.00	
3	Халаалтын тогоо	42 ква цахилгаан	м.кв	864	8,524.40	7,365,081.60	
4	Генератор	100 ква дизель	ш	1	13,597,080.00	13,597,080.00	Нийслэлийн өмчид
4	Гадна хашаа	Бетон суурьтай төмөр хашаа-2 м өндөр	м.кв	360	116,446.76	41,920,833.60	
5	Мод /ногоон байгууламж/	Нарс	ш	6	154,166.67	925,000.02	
5	Явган зам талбай	Бетон талбай	м.куб	50	145,000.00	7,250,000.00	
Нийслэлийн өмчид бүртгэх нийт дүн							
6	КТПН	160 ква	ш	1	33,992,700.00	33,992,700.00	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК
Нийт дүн						1,783,305,172.82	(нэг тэрбум долоон зуун наян гурван сая гурван зуун таван мянган нэг зуун далан хоёр төгрөг наян хоёр мөнгө)